

ХАН-УУЛ ДҮҮРГИЙН АЛБАН БУС-НАСАН ТУРШИЙН БОЛОВСРОЛЫН ТӨВИЙН 2022  
ОНЫ СУРГАН ХӨГЖҮҮЛЭХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТАЙЛАН

2022 оны 11 дүгээр сарын 22

Улаанбаатар хот

Байгууллага 2020-2023 оны сурган хөгжүүлэх хөтөлбөртэй. Хөтөлбөрт заагдсан үйл ажиллагааг жил жилээр төлөвлөгөө гарган хэрэгжилтэд хяналт тавьж ажилладаг.

А. 2022 оны Сурган хөгжүүлэх төлөвлөгөө нь 2 үндсэн зорилтын хүрээнд 11 ажлыг төлөвлөж 100% хэрэгжүүлэн ажиллав.

**Зорилт 1:** Багш, ажилчдын мэдлэг боловсролыг дээшлүүлэх

1. Байгууллагад 3 дахь жилдээ ажиллаж байгаа С.Энхзаяаг МУБИС-д магистраар сурахад дэмжлэг үзүүлэв.

2. Энэ хичээлийн жилд анхны жилдээ ажиллаж байгаа О.Лхагвасүрэн, 5 дахь жилдээ ажиллаж байгаа багш С.Анхтуяа, Ц.Дуламсүрэн нар сургалтад хамрагдсан.

3. Багш ажилтнуудыг “Өөрийгөө хөгжүүлэх төлөвлөгөө”-г хэрхэн хийх сургалтад хамруулж, төлөвлөгөө гаргуулан хяналт тавин ажиллаж байна.

4. 2022 оныг боловсролын салбар Ёс зүйн жил болгосонтой холбоотойгоор ёс зүйн зөвлөл болон түүний ажиллах журмыг баталсан. Ажилчин багш хаагчдын ёс зүйн сургалтад 3 удаа хамруулсан.

5. 2022 онд Үндэсний хэмжээний сургагч багш 5-ыг бэлтгэлээ. Үүнд:

- Гамшгийн эрсдэлийг бууруулах “БЭЛЭН БАЙ” сургагч багшийн сургалтад багш С.Энхзаяа, А.Болормаа, Ц.Дуламсүрэн нар
- “Тэрбум мод тарих үндэсний хөтөлбөр”-ийн хүрээнд багш О.Лхагвасүрэн “Мод тарих үндэсний сургагч багш”
- Боловсролын ерөнхий газар, НҮБ-ын Хүн амын сантай хамтран зохион байгуулж буй малчдад амьдрах ухааны боловсрол олгох сургагч багш бэлтгэх сургалтад багш С.Анхтуяа
- Багш А.Болормаа, Б.Эрдэнэдулам нар Гэр бүлийн боловсролын сургагч багш
- Сургалтын менежер Ч.Гантуяа “Монголын боловсрол өнөөдөр” үндэсний суурь судалгааны судлаач- сургагч багшаар бэлтгэгдэв.

6 Хөрвүүлэх мэргэжлийн сургалтад хамрагдахад дэмжлэг үзүүлэх

-Оёдол эсгүүрийн багш Г.Дуламрагчааг МУБИС-ийн дизайн технологийн сургалтад сургаж -байна.

7. Англи хэлний анхан болон дунд шатны сургалтад хамруулах

Англи хэлний анхан шатны сургалтад багш А.Болормаа, Б.Эрдэнэдулам, О.Лхагвасүрэн, Т.Нямтулга, Г.Түвшинжаргал, Ц.Дуламсүрэн, Г.Дуламрагчаа, Б.Долгор, нийгмийн ажилтан О.Мягмарсүрэн дунд шатны сургалтад захирал Т.Рэгзэдмаа, сургалтын менежер Ч.Гантуяа, багш С.Анхтуяа нар хамрагдлаа.

8. Монгол бичгийн анхан болон дунд шатны сургалтад хамруулах

Монгол бичгийн анхан шатны сургалтад багш Б.Эрдэнэдулам, О.Лхагвасүрэн, Т.Нямтулга, Г.Түвшинжаргал, Г.Дуламрагчаа, Б.Долгор, нийгмийн ажилтан



О.Мягмарсүрэн дунд шатны сургалтад захирал Т.Рэгзэдмаа, багш А.Болормаа, Ц.Дуламсүрэн нар хамрагдав.

9. Албан хэрэг хөтлөлтийн стандарт мөрдөх сургалтад хамруулах

Албан хэрэг хөтлөлтийн стандартын сургалтыг багш Ц.Дуламсүрэн зохион байгуулж бүх багш, ажилчид хамрагдаж, байгууллага сургалтын РРТ-ний шинэ загвартай боллоо.

**Зорилт 2:** Багш,ажилчдыг үр дүн бүтээлтэй, тогтвор суурьшилтай ажиллуулах

1. Магистрын сургалтад хамрагдсан багш С.Энхзаяа, бакалаврын сургалтаа амжилттай дүүргэсэн багш О.Лхагвсүрэн, хөрвөх сургалтад хамрагдаж буй багш С.Дуламрагчаа нарыг албан тушаалын цалинг олгон сургаж байна.

2. 2022 онд Багануур дүүрэг, Дархан-Уул аймгийн НТБТ-ийн үйл ажиллагаатай танилцаж, харилцан туршлага солилцон ажиллав.

3. Багш ажилчдын дунд:

- Хувийн хүний хөгжлийн төлөвлөгөөг хэрхэн хийж, үр дүнд хүрэх
- Албан хэргийн стандартын зөв мөрдөх
- Хамтын хичээлийг хэрхэн зохион байгуулах сургалтыг зохион байгууллаа.

4. Хамт олны уур амьсгал, харилцаа хандлагыг дээшлүүлэх талаар:

- Ёс зүй, харилцаа, хандлага сэдвээр МУИС-ийн багш С.Дарьхүүгээр сургалт зохион байгуулж, нийслэлийн 9 дүүргийн багш нарыг хамруулав.
- Байгууллагын ёс зүйн зөвлөл 2 удаа санал асуулга авч байгууллага дээрх анхаарах асуудлыг танилцуулж, харилцаа хандлагыг хэрхэн өөрчлөх талаар сургалт зохион байгуулсан
- Мөн “Өглөөний цай” арга хэмжээг 2 удаа зохион байгуулж, хамт олны уур амьсгал, харилцаа, хандлагын талаар ярилцлага зохион байгуулсан

5. Багш ажилчдаар хагас болон бүтэн жилээр тайлан тавиулахын зэрэгцээ сар бүрийн ажлын үнэлгээг үндэслэн тэргүүний багш ажилчдын шалгаруулах, шагнаж урамшуулах ажлыг жил бүр зохион байгуулдаг.

2022 онд багш Т.Нямтулга, Г.Түвшинжаргал, Ц.Дуламсүрэн нарыг Дүүргийн Иргэдийн Хурлын “Хүндэт тэмдэг”-ээр шагналаар шагнаж урамшуулав.

ТАЙЛАН БИЧСЭН:

НИЙГМИЙН АЖИЛТАН *О.Мягмарсүрэн* О.МЯГМАРСҮРЭН

ХЯНАСАН:

ЗАХИРАЛ *Т.Рэгзэдмаа*

Т.РЭГЗЭДМАА

